



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**

Жуулчны гудамж 5, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 41 52, Факс: (976-11) 32 66 11,
Цахим шуудан: info@namem.gov.mn

2024.12.02 № 01/1106

танай _____-ны № _____-т

**БАЙГАЛЬ ОРЧИН, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН
САЙД С.ОДОНТУЯА ТАНАА**

Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 100 дугаар тушаалыг үндэслэн тус газрын 2024 оны гүйцэтгэлийн тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт ⁵⁰ хуудастай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХ
ХЭЛТСИЙН ДАРГА  Д.ОЮУНЖАРГАЛ



153241714

d:\2024\root\12.02-1106.docx

Цаг уур, орчны шинжилгээний газрын
2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн
01/1106 дугаар албан бичгийн хавсралт



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв сая ₮	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
НЭГ.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт							
Стратеги төлөвлөгөөний зорилго: “Монгол Алсын хараа–2050 хөгжлийн хөтөлбөрт тулгуурлан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний хүрээнд, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6.1.3, /ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 5.1.1.2.3/							
1	Зорилт 1: Ус цаг уур, байгаль орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний хэвийн үйл ажиллагаа, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, техник технологийн шинэчлэл хийх	Улсын төсөв	Ус цаг уур, байгаль орчны хяналт, шинжилгээний улсын сүлжээний автоматжуулалтын хувь	65	72	Ус судлалын харуулд шаардлагатай 17 автомат станц суурилуулж ашигласнаар 154 ус судлалын харуулын 11 хувь автомат тоног төхөөрөмжөөр хангагдаж байна. Ингэснээр Улсын сүлжээний автоматжуулалт 76 хувьд хүрсэн. Цаг уурын сүлжээний автоматжуулалт – 65 хувь, Ус судлалын сүлжээний автоматжуулалт – 11 хувь байна. Биелэлт – 100 хувь	100%
			Ус цаг уур, байгаль орчны хяналт, шинжилгээний улсын сүлжээний	70	75	Улсын сүлжээний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагын урсгал зардлаас Цаг уурын сүлжээнд 380 сая, аэрологийн шинжилгээнд 640 сая, Ус судлалын сүлжээнд 326 сая, орчны шинжилгээнд 170 орчим сая	

1	2	3	4	5	6	7	8
			хөтөлбөрийн биелэлтийн хувь			төгрөгөөр шаардлагатай хэмжих хэрэгсэл, сэлбэг материал, урвалж бодис худалдан авч үйл ажиллагаандаа ашиглалаа. Үүний үр дүнд Цаг уурын сүлжээний хөтөлбөрийн хэрэгжилт 85 хувь, Ус судлалын харуулын хөтөлбөрийн биелэлт 90 хувь, орчны шинжилгээний хөтөлбөрийн биелэлт 100 хувь байна. Биелэлт-100 хувь	
1.1	Өвөрхангай аймгийн УЦУОШТ-д аэрологийн шинжилгээний өртөө байгуулах	Гадаад зээл тусламж	Үйл ажиллагааны явц, хэрэгжилт	0	Өртөө байгуулж, хөөргөлт хийж эхэлсэн байна	БНСУ-ын буцалтгүй тусламжийн төслөөр Өвөрхангай аймагт Аэрологийн станц байгуулах бэлтгэл ажлыг хангасан. Төсөл хэрэгжүүлэх БНСУ-ын мэргэжилтнүүд ЦУОШГ болон Өвөрхангай аймагт ажиллахаар 11 дүгээр сард ирсэн. Бэлтгэлт ажлын хүрээнд газ генераторын байрыг цахилгаанд холбоход шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэж, байшинд их засвар хийсэн. Суурилуулах тоног төхөөрөмжийг БНСУ-ын төслийн гүйцэтгэгч компаниас ирүүлэхийг хүлээж байгаа.12 дугаар сарын 20-ны дотор суурилуулж дуусна.	100%
1.2	Цаг уурын автомат станц 25 ширхгийг худалдан авч суурилуулах	Улсын төсөв	Автомат станцаар хангагдсан өртөө, харуулын тоо	205	230	БОАЖ-ын Сайдын багцаас 2.5 тэрбум төгрөгийг шийдвэрлэж Цаг уурын автомат станц 25 ширхгийг худалдан авахаар тендер зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажилласан. 10 дугаарын сарын 25-нд 25 иж бүрдэл цаг уурын автомат станцыг хүлээн авч, Газрын даргын баталсан хуваарийн дагуу УЦУОШТ-д олгож байна. Суурилуулахын өмнөх тохиргоо хийгдэж, Дундговь, Сэлэнгэ аймгууд суурилуулж эхлээд байна. суурилуулалт дуусахад нийт 230 автомат станцтай болно	100%

1	2	3	4	5	6	7	8
1.3	Ус судлалын 16 харуулд мэдээлэл нь нээлттэй харагддаг усны түвшин хэмжих автомат багаж суурилуулах	Улсын төсөв	Автомат түвшин хэмжигч багаж суурилуулсан харуулын тоо	0	16	БОАЖ-ын Сайдын багцаас 2 тэрбум төгрөгийг шийдвэрлэж Ус судлалын автомат хэмжих хэрэгсэл 17 иж бүрдлийг худалдан авахаар техникийн тодорхойлолтыг боловсруулан, худалдан авах нээлттэй тендер зарлахад тус тендэрт "Мэйжүрмэнт" ХХК Австри улсад байрлах "Соммер" компаний үйлдвэрлэдэг RQ-30 багажийг 17 ширхгийг нийлүүлэхээр гэрээ байгуулсан. тендэрт тусгасан шаардлагын дагуу "Соммер" компаний мэргэжилтэн ирж 1 багажийг Зайсангийн гүүрэн дээр суурилуулж багажийг ашиглах, мэдээ авах, дамжуулах талаарх сургалтыг хийж, багажийг хүлээлгэн өгөв. 12/20-ний дотор үлдсэнийг хүлээлгэн өгнө.	100%
1.4	Ус судлалын харуулд мэдээлэл нь хаалттай /Offline/ усны түвшин хэмжих автомат багаж суурилуулах	Улсын төсөв	Автомат түвшин хэмжигчээр тоногдсон харуулын тоо	39	44	ЦУОШГ-ын урсгал зардлаар хаалттай горимд ажилладаг түвшин хэмжигч автомат багаж 5 ширхгийг худалдан авч хуваарийн дагуу олгож суурилуулсан. нийт 44 болсон	100%
1.5	Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн шинэ барилгын ажлыг эхлүүлэх, дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангах	Гадаад зээл тусламж	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт дууссан	ТЭЗҮ-ийг боловсруулсан байна, барилгын ажил эхлүүлсэн байна	Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн барилгын зураг төсөл боловсруулах архитектур төлөвлөлтийн даалгаврыг нийслэлийн Ерөнхий архитектораар 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдөр батлуулж гүйцэтгэгчид хүргүүлсэн. Төслийн ТЭЗҮ-д туссан лабораторийн багаж тоног төхөөрөмж, агаарын чанарын суурийн харуулын багаж тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн техникийн тодорхойлолтыг боловсруулж, шинээр баригдах лабораторийн барилгын ерөнхий дизайн, барилгын давхрын төлөвлөлтийг батлуулсан. Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн барилгын	100%

1	2	3	4	5	6	7	8
						загвар зургийг нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар батлуулсан. Сар бүрийн 2 болон 4 дэх долоо хоногийн Баасан гарагт зөвлөх үйлчилгээний ажлын явцын тухай цахим уулзалт зохион байгуулж, гүйцэтгэгч болон захиалагч талаас хэрэгжүүлэх ажлын явц, гүйцэтгэлийг хянан ажиллаж байна.	
1.6	Томоохон хот, суурин газруудад агаарын чанарыг 5-аас доошгүй үзүүлэлтээр хянах боломжийг бүрдүүлэх	Гадаад зээл тусламж	Агаарын чанарыг 5-аас доошгүй үзүүлэлтээр тасралтгүй, автоматаар хянах боломжийг бүрдүүлсэн аймгийн тоо	0	5	21 аймгийн төвд агаарын чанарын автомат харуул суурилуулах, улсын сүлжээний чадавхыг бэхжүүлэх төслийн хүрээнд 2024 онд Дархан-Уул, Орхон, Завхан, Увс, Хөвсгөл, Хэнтий, Архангай аймагт Агаарын чанарыг хянах автомат багаж суурилуулахад БНСУ-ын К-есо байгууллагатай хамтран ажиллаж бэлтгэл ажлыг хангаад байна. Төслийн хүрээнд багаж, тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийг БНСУ-д зарлаж гүйцэтгэгч байгууллагыг шалгаруулж гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд тендерт шалгарсан Кентек компани 11 дүгээр сарын 5-12-ны өдрүүдэд дээрх аймгуудаар явж, бэлтгэл ажил байдалтай танилцсан. Дээрх 7 аймгийн агаарын чанарыг тодорхойлох багаж, тоног төхөөрөмжийг 2025 оны 1-2-р улиралд суурилуулж дуусахаар гэрээ байгуулагдсан байна.	90%
2	Зорилт 2: Цаг агаарт зориудаар нөлөөлөх арга технологийг боловсронгуй болгох	Улсын төсөв	1.Хур тунадас нэмэгдүүлэх 2. Ойн түймэр унтраах 3. Мөндөр сарниулах арга технологи боловсронгуй болгосон	1.Хур тунадас нэмэгдүүлэх 2.Ойн түймэр унтраах	1.Хур тунадас нэмэгдүүлэх 2. Ойн түймэр унтраах 3. Мөндөр сарниулах	1.Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх, Ой хээрийн түймэр ундраахад дэмжлэг үзүүлэх 2024 оны үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангав. Үүнд: УУХҮЯ-наас олгодог Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд ашиглах пуужин импортлох, ашиглах "Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөл"-ийн хугацааг 5 жилээр сунгуулж, ИНЕГ-тай хамтран ажиллах	70%

1	2	3	4	5	6	7	8
			бүтээгдэхүүн үйлчилгээний тоо			гэрээг шинэчлэн байгууллаа. Газрын даргын тушаалаараа 2024 оны 05 дугаар сарын 22-ноос 09 дүгээр сарын 15-ныг хүртэл Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх, ой хээрийн түймэр унтраахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг 17 экспедиц 208 удаа явуулж 497 пуужин зарцуулж ажиллаа.	
2.1	Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд шинэ техник, технологи нэвтрүүлэх	Улсын төсөв	Мөндөр сарниулах тоног төхөөрөмж худалдан авч, туршилт хийсэн байдал, хувь	0	Тоног төхөөрөмж худалдан авч, туршилт хийсэн байна	Мөндөр сарниулах туршилтын үйл ажиллагаа явуулах зорилгоор мөндөр сарниулах 30ш пуужин, харвах суурийн хамтаар худалдан авахаар үнийн судалгаа хийсэн бөгөөд БНХАУ-ын тус пуужинг үйлдвэрлэгч компаниас үйлдвэрлэх болон тэсэрч дэлбэрэх ачаа хилийн боомтоор нэвтрүүлэхэд хугацаа их шаардах тул 2024 онд багтаан нийлүүлэх боломжгүй тухай мэдэгдсэн. Иймд 2025 онд худалдан авахаар хүлээгдэж байна.	0%
ХОЁР. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
Стратеги төлөвлөгөөний зорилго: "Монгол Алсын хараа–2050 хөгжлийн хөтөлбөрт тулгуурлан "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний хүрээнд, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 13, 15, 6.1.3, 14.1, 6.1.6 заалт							
3	Зорилт 3: Ус, цаг агаар, орчны бодит болон урьдчилсан мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг тасралтгүй шуурхай хангах	Улсын төсөв	Бүх төрлийн урьдчилсан мэдээний чанарыг сайжруулсан хувь	0.0	0.8	Салбарын бүтээгдэхүүн үйлчилгээний чанар 1.5 хувиар өссөн байна.	100%
3.1	Хот, суурины 5 хоногийн мэдээний чанарыг сайжруулах;	Улсын төсөв	Урьдчилсан мэдээний таарц, хувь	87.6	88.0	87.3% 2024 оны цаг агаарын нөхцөл байдал харьцангуй эрс өөрчлөлт ихтэй байсан нь мэдээний чанар багасахад нөлөөлсөн. Инерцийн прогнозын таарц эхний 10 сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 9 орчим	99.2%

1	2	3	4	5	6	7	8
						хувиар бага байгаа нь өөрчлөлт ихтэй байсныг гэрчилж байна	
3.2	Хот, суурины төвөөр зохиосон хоногийн мэдээний чанарыг сайжруулах	Улсын төсөв	Урьдчилсан мэдээний таарц, хувь	92.1	92.2	91.9% 2024 оны цаг агаарын нөхцөл байдал харьцангуй эрс өөрчлөлт ихтэй байсан нь мэдээний чанар багасахад нөлөөлсөн. Инерцийн прогнозын таарц эхний 10 сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 9 орчим хувиар бага байгаа нь өөрчлөлт ихтэй байсныг гэрчилж байна	99.7%
3.3	Ус, цаг агаар, орчны бүх төрлийн мэдээлэл, аюулт үзэгдэл, гамшгийн тухай урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээх ажлыг өргөжүүлэх	Улсын төсөв	Бэлтгэн түгээсэн бичвэр, үзүүлэн /слайд/, бичлэг, нэвтрүүлгийн тоо, хэмжээ	Бичвэр болон зурагтай мэдээний тоо – 1863 удаагийн мэдээлэл Бүх төрлийн бичлэг /видео/ мэдээлэл – 1150 удаагийн мэдээлэл бэлтгэсэн	Бичвэр, үзүүлэн /слайд/ мэдээ – 1863-аас дээш удаа, Бичлэг, нэвтрүүлгийн тоо-1150-аас доошгүй байна	1992 төрлийн текст, зураг, график бүхий мэдээлэл, 784 танин мэдэхүй, зөвлөмж, цаг агаарын өдөр тутмын болон урьдчилсан мэдээний бичлэг, нэвтрүүлэг бэлтгэн олон нийтийн сүлжээгээр нийтэд хүргэсэн. /Нийтэд хүргэсэн мэдээлэл-2776/	100%
		Улсын төсөв	Онцгой байдлын ерөнхий газрын шуурхай мэдээллийн сувгаар шуурхай хүргэсэн байдал, Tsag-agaar.gov.mn, weather.gov.mn сайтуудын хэрэглэгчийн тоо, Цаг агаар апп-ын хэрэглэгчийн тоо, Ус цаг агаар, орчны мэдээ мэдээлэл фэйсбүүк пэйжийн хэрэглэгчдийн тоо, хандалтын тоо	Онцгой байдлын ерөнхий газрын тусгай сувгаар 63 удаа Урьдчилан сээрэмжлүүлэх мэдээ, сээрэмжлүүлэх мэдээний мэдээллийг хүргэсэн. Фейсбүүк пэйж хуудсанд 107000 дагагчтай байна. www.tsag-agaar.gov.mn цахим хуудасны хэрэглэгчдийн тоо 9 сая 800 мянгад хүрсэн	Урьдчилан сээрэмжлүүлэх мэдээ, сээрэмжлүүлэх мэдээний мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын шуурхай мэдээллийн сувгаар бүрэн түгээнэ, Ус цаг агаар, орчны мэдээ мэдээлэл фэйсбүүк пэйжийн хэрэглэгчдийн тоо 122000-д хүргэнэ, weather.gov.mn цахим хуудсанд хандалтын тоо 5 сая гаруйд хүргэнэ	Ус цаг агаар, орчны мэдээ мэдээлэл фэйсбүүк хуудасны дагагчдын тоо 11 дүгээр сарын 30 өдрийн байдлаар 119,000 болж өссөн. Weather.gov.mn вэб сайт 2024 оны 1-р сарын 1-нээс шинээр ажиллаж эхэлсэн бөгөөд хандалтын тоо 6.838.569 сая байна. /Хэрэглэгчдийн тоо – 12 мянгаар өссөн/	100%

1	2	3	4	5	6	7	8
3.4	Хуурайшлын зэргийн мэдээллээр хуульд заасан хугацаанд БОАЖЯ, ОБЕГ зэрэг холбогдох байгууллага, мэргэжилтнүүдэд шуурхай үйлчлэх	Улсын төсөв	Үйлчилсэн хоногийн тоо	130	130-аас дээш	Хуулийн хугацаанд буюу 3/20-ноос эхлэн өнөөдрийг хүртэл 240 гаруй өдөр бүр мэдээллээр үйлчилж байна. Олон нийтэд хүргэдэг хуурайшлын зургийг шинэчилсэн	100%
3.5	Орон нутгийн түвшинд гаргасан цаг агаарын урьдчилсан мэдээний чанарыг дээшлүүлэх	Улсын төсөв	1 хоногийн урьдчилсан мэдээний таарц	93.8	93.9	93.4% байна. 2024 оны цаг агаарын нөхцөл байдал харьцангуй эрс өөрчлөлт ихтэй байсан нь мэдээний чанар багасахад нөлөөлсөн. Инерцийн прогнозын таарц эхний 10 сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 9 орчим хувиар бага байгаа нь өөрчлөлт ихтэй байсныг гэрчилж байна	99.7%
			5 хоногийн урьдчилсан мэдээний таарц	88.8	88.9	88.6% байна. 2024 оны цаг агаарын нөхцөл байдал харьцангуй эрс өөрчлөлт ихтэй байсан нь мэдээний чанар багасахад нөлөөлсөн. Инерцийн прогнозын таарц эхний 10 сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 9 орчим хувиар бага байгаа нь өөрчлөлт ихтэй байсныг гэрчилж байна	99.7%
3.6	Нислэгт зориулсан цаг агаарын мэдээний чанарыг сайжруулах	Улсын төсөв	Урьдчилсан мэдээний чанар олон улсын дундаж 80.0 хувиас дээш	95.6	95.6	94.94%	99.3%
			Бодит ажиглалтын мэдээний чанар 95 хувиас дээш	99.9	99.9	100%	100%
			1. Сарын урьдчилсан мэдээний таарц, хувь	60.0	60-аас дээш	2024 оны 2-10 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээ гаргахад шаардлагатай арга загваруудыг ажиллуулж, үр дүнг нэгтгэн, хэлтсээр хэлэлцүүлж, сарын урьдчилсан мэдээ гаргаж олон нийтэд хүргэсэн.	100%

1	2	3	4	5	6	7	8
3.7	Сар, улирлын урьдчилсан төлөвийн таарцыг сайжруулах	Улсын төсөв				<ul style="list-style-type: none"> ○ 12 сард гаргасан 1 сар 48.3 хувь (ТЕМ: 37.9%, ТУН:58.6%) ○ 1 сард гаргасан 2 сар 65.2 хувь (ТЕМ: 74.6%, ТУН:55.7%) ○ 2 сард гаргасан 3 сар 60.5 хувь (ТЕМ: 71.1%, ТУН:50.0%) ○ 3 сард гаргасан 4 сар 57.7 хувь (ТЕМ: 61.7%, ТУН:53.6%) ○ 4 сард гаргасан 5 сар 69.7 хувь (ТЕМ: 76.4%, ТУН:62.9%) ○ 5 сард гаргасан 6 сар 76.5 хувь (ТЕМ: 89.3%, ТУН:63.6%) ○ 6 сард гаргасан 7 сар 61.9 хувь (ТЕМ: 64.4%, ТУН:59.3%) ○ 7 сард гаргасан 8 сар 80.6 хувь (ТЕМ: 96.8%, ТУН:64.3%) ○ 8 сард гаргасан 9 сар 69.3 хувь (ТЕМ: 78.6%, ТУН:60.0%) <p>Сарын урьдчилсан мэдээний таарц 67.7% байна.</p>	
			2. Улирлын урьдчилсан төлөвийн таарц, хувь	58.0	58-аас дээш	<p>2024 оны 3-5, 4-6, 5-7, 6-8, 7-9, 8-10, 9-11, 11-01 дугаар саруудын улирлын урьдчилсан төлөв гаргахад шаардлагатай арга загваруудыг ажиллуулж, үр дүнг нэгтгэн, хэлтсээр хэлэлцүүлж, улирлын урьдчилсан мэдээгээр олон нийтэд үйлчилсэн.</p> <ul style="list-style-type: none"> ○ 9 сард гаргасан 11, 12, 1 сарын дундаж таарц 58.1% (ТЕМ: 53.9%, ТУН: 62.3%) ○ 10 сард гаргасан 12, 1, 2 сарын дундаж таарц 55.7% (ТЕМ: 48.4%, ТУН: 63.0%) ○ 11 сард гаргасан 1, 2, 3 сарын дундаж таарц 56.1% (ТЕМ: 45.5%, ТУН: 66.7%) ○ 12 сард гаргасан 2, 3, 4 сарын дундаж таарц 54.8% (ТЕМ: 54.7%, ТУН: 54.9%) ○ 1 сард гаргасан 3, 4, 5 сарын дундаж таарц 54.8% (ТЕМ: 45.7%, ТУН: 63.8%) ○ 2 сард гаргасан 4, 5, 6 сарын дундаж таарц 72.4% (ТЕМ: 78.4%, ТУН: 66.4%) ○ 3 сард гаргасан 5, 6, 7 сарын дундаж таарц 64.5% (ТЕМ: 62.1%, ТУН: 66.9%) 	100%

1	2	3	4	5	6	7	8
						<ul style="list-style-type: none"> o 4 сард гаргасан 6, 7, 8 сарын дундаж таарц 52.9% (ТЕМ: 43.9%, ТУН: 61.9%) o 5 сард гаргасан 7, 8, 9 сарын дундаж таарц 70.7% (ТЕМ: 78.9%, ТУН: 62.4%) o 6 сард гаргасан 7, 8 сарын дундаж таарц 63.0% (ТЕМ: 64.8%, ТУН: 61.1%) o 7 сард гаргасан 9 сарын дундаж таарц 54.3% (ТЕМ: 50.0%, ТУН: 58.6%) <p>Улирлын урьдчилсан төлөвийн таарц 59.7% байна.</p>	
3.8	Гадаргын усны урьдчилсан мэдээ, зөвлөмжөөр үйлчлэх	Улсын төсөв	1.30 голын сарын урсцын прогнозын таарц, хувь	66.0	70.0	<p>Шар усны үерийн прогнозыг 5 удаа нийт 27 сав газраар гаргаж хэрэглэгчдэд хүргэв. 2024 оны хаврын мөсний үзэгдэл эхлэх болон гол мөрөн мөснөөс бүрэн чөлөөлөгдөх, намрын мөсний үзэгдэл эхлэх болон гол мөрөн хадаалах хугацааны прогнозыг 30 гол харуулаар гаргаж хэрэглэгчдэд хүргэв. Сарын дундаж урсцын прогноз 5-7 саруудад 30 гол харуулаар, прогнозын шинэ аргагүйгээр 8, 9 саруудад 13 гол харуулаар гаргаж хэрэглэгчдэд үйлчлэв. 5-9 дүгээр саруудын дундаж таарц 68.2% таарцтай байна.</p>	97.4%
			2.20 голын усны түвшний богино хугацааны прогнозын таарц, хувь	71.6	73.5	<p>Богино хугацааны прогнозын шинэчилсэн тэгшитгэлээр 5-9 дүгээр саруудад үерийн прогнозыг 20 гол харуулаар гаргаж, харьцуулан дүн шинжилгээ хийж үйлчлэв. Богино хугацааны прогнозын дундаж таарц 72.6 хувь байна.</p>	98.7%
3.9	Хөдөө аж ахуйн цаг уурын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	Улсын төсөв	1.Газар тариалангийн үйлдвэрлэлд зориулсан буудайн ургалтын үе шатны прогнозын таарц, хувь	70.0	70.6	<p>Буудайн аарцан бололтын үе шат илрэх хугацааны, хөрс гэсэж эхлэх хугацааны, хөрсний угтвар чийгийн урьдчилсан мэдээ, агро зөвлөмжийг боловсруулан гаргасан. Газар тариалангийн үйлдвэрлэлд цаг агаарын нөхцөл хэрхэн нөлөөлсөн талаар 10 хоног, сар улирал, жилийн тоймонд тусгахаас гадна, бусад зөвлөмж, урьдчилсан мэдээг тухай бүрт гарган цахим хуудсанд байршуулсан.</p>	100%

1	2	3	4	5	6	7	8
						Буудайн аарцан бололтын үе шат илрэх хугацааны урьдчилсан мэдээний таарц 82.9% , улаанбуудайн ургац- 77.7% , төмсний ургац- 71.3% байв.	
			2.Мал аж ахуйд зориулсан малын амьдын жингийн өсөлт бууралтын прогнозын таарц, хувь	80.0	85.0	Арав хоног, сар, улирлын тойм мал аж ахуйн үйлдвэрлэлд цаг агаар хэрхэн нөлөөлсөн талаар тойм мэдээлэл, мал төллөх үеийн цаг агаарын нөхцөлийн зөвлөмжийг боловсруулан нийтэд мэдээлсэн. Эм хонины тарга хүчний өсөлтийн урьдчилсан мэдээг гаргасан. Таарц 89% байв.	100%
			3.Өвөл - хаврын бэлчээрийн даацын үнэлгээ, багийн түвшин	2023 оны VIII сарын сүүлийн арав хоногт гаргасан	2024-2025 оны өвөл-хаврын бэлчээрийн даацыг багийн нутгаар тооцоолон гаргаж, зураглан нийтэд мэдээлсэн байна	Монгол орны хэмжээгээр багийн түвшинд бэлчээрийн даацыг 8 дугаар сарын сүүлчийн арав хоногт тооцоолоход: 47%-бэлчээрийн нөөцтэй, 20%-бэлчээр хүрэлцээтэй, 21%-даац 1-3 дахин хэтэрсэн, 4%-даац 3-5 дахин хэтэрсэн, 8%-даац олон дахин хэтэрч гарсан.	100%
			4.Ган, зудыг үнэлгээ хийх, зудын эрсдэлийн мэдээг тухай бүрт гаргах тоо	Зудын эрсдэлийн зургийг нөхцөл байдлаас хамаарч 5 удаа боловсруулсан	2024-2025 оны Зудын эрсдэлийн зургийг 11 дүгээр сарын сүүлийн хагаст гаргаж, нийтэд мэдээлсэн байна.	Ган, зуншлагын байдлыг дулааны улиралд 9 удаа, цас зудын байдлыг 4 удаа тус тус үнэлсэн (хүлээгдэж буй үр дүн). Зудын эрсдэлийн үнэлгээг 11 дүгээр сарын 30-ны байдлаар 1 удаа гаргаад байна. Цаашид өвөлжилтийн байдал хүндрэх тухай бүр шинэчлэн боловсруулна.	100%
3.10	Уур амьсгалын сар, жилийн тойм мэдээгээр үйлчлэх	Улсын төсөв	Сарын тоймын тоо	2023 онд нийт 12 удаа сарын тойм гаргасан	Сар бүрийн 5-ны дотор гаргаж, хэрэглэгчдэд хүргэсэн байна	137 өртөөний 2023 оны 12 сар болон 2024 оны 1-11 дүгээр сарын тайланг хүлээн авч, тухайн саруудын эмхэтгэлийг боловсруулж, сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД /олон жилийн дундаж/-аас хазайх хазайлтын тархалт болон хоногийн явц, тухайн сард ажиглагдсан үнэмлэхүй их, бага утга, 30 градус цельсээс хүйтэн өдрийн тоогоор	100%

1	2	3	4	5	6	7	8
						тойм бичиж, хугацаанд нь сайтад 12 удаа байршуулсан.	
			Жилийн тойм тоо	2022 оны уур амьсгалын тоймыг 1 сарын 20-ны дотор гаргаж, хэрэглэгчдэд хүргэсэн	2023 оны уур амьсгалын жилийн тоймыг 1 сарын 20-ны дотор гаргаж хэрэглэгчдэд хүргэсэн байна	2023 оны уур амьсгалын жилийн эмхэтгэлийг 137 өртөөгөөр, 70 гаруй элементүүдээр гаргаж, жил, улирлын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт, экстремаль утгуудаар тархалтын зураг, график үйлдэж, 2023 оны уур амьсгалын тоймын бичиглэлийг хийж, цахим хуудсанд байрлуулж хэрэглэгчдэд хүргэсэн.	100%
3.11	Цаасан суурьтай баримт болон тоон мэдээллээр хэрэглэгчдэд үйлчлэх, үйлчилгээг өргөжүүлэх	Улсын төсөв	Орлогын хэмжээ, төг	30 сая	32 сая	Егр-гаар албан бичгээр 102 албан байгууллага, өргөдөл хүсэлтээр 42 иргэн, цахим хаягаар нийт 157 хэрэглэгч хандсанд хүсэлт тухай бүрийг түргэн шуурхай үйлчилж хариуг шийдвэрлэж ажилласан. Хэрэглэгчдээс https://weather.gov.mn/цахим хуудсаар 848 хэрэглэгч хандаж 180 хэрэглэгч үйлчилгээ авч 2.184.000 төгрөгний орлого орсон. Албан ёсны цахим шуудан info@namem.gov.mn -аар дамжуулан цахим хаягаар гадаад харилцааны хэрэгцээнд 5 удаа мэдээ гаргаж өгсөн. Нийт 753 станц, 695 харуулын 587 төрлийн мэдээгээр 102 албан байгууллага, 54 хувь хүн, төлбөргүй 45, төлбөртэй 112, онлайнаар 180 нийт 337 хэрэглэгчдэд үйлчилж төрийн санд 63.476.173 төгрөгийн орлого оруулсан.	100%
		Улсын төсөв	Орчны чанарын хяналт шинжилгээний тайлан гаргасан байна	Агаар, ус, хөрсний чанарын 2019-2020 оны төлөв байдлын тайлан гаргаж БОАЖЯ-д өгсөн	Агаар, ус, хөрсний чанарын 2021-2022 оны төлөв байдлын тайлан гаргаж БОАЖЯ-д өгнө	Монгол Улсын байгаль орчны төлөв байдлын 2021-2023 оны тайланд агаар, ус, хөрсний чанарын төлөв байдлын тайлан бэлтгэн БОАЖЯ-ны асуудал хариуцсан мэргэжилтэн руу 2024 оны 04 сард цахимаар илгээсэн байна.	100%

1	2	3	4	5	6	7	8
3.12	Агаар, ус, хөрс, цацрагийн хяналт шинжилгээний ажлын үр дүнг нэгтгэн боловсруулж, мэдээ, мэдээллээр үйлчлэх, Байгаль орчны төлөв байдлын нэгдсэн тайлан гаргах		Агаар, ус, хөрс, цацрагийн хяналт шинжилгээний мэдээ, мэдээллийн үйлчилсэн тоо	Агаарын чанарын хяналт шинжилгээний 7 хоногийн мэдээ 52, сарын мэдээ 12, хүйтний улирлын мэдээ 7, жилийн тайлан 1, БОХ маягт-1, Байгаль орчны цацрагийн төлөв байдлын тайлан-1, гадаргын усны 193 хяналт шинжилгээний цэгийн дүн-1, Гадаргын усны чанарын жилийн мэдээ-1 удаа гаргасан	Агаарын чанарын хяналт шинжилгээний 7 хоногийн мэдээ 52, сарын мэдээ 12, хүйтний улирлын мэдээ 7, жилийн тайлан 1, БОХ маягт-1, Байгаль орчны цацрагийн төлөв байдлын тайлан-1, гадаргын усны 193 хяналт шинжилгээний цэгийн дүн-1, Гадаргын усны чанарын жилийн мэдээ-1 удаа гаргасан байна	Агаар, ус, хөрсний чанарын 2023 оны төлөв байдлын тайлан гаргаж агаар.mn, weather.gov.mn цахим хуудсанд байршуулан мэргэжлийн байгууллага, олон нийтэд мэдээ мэдээллээр үйлчилж байна. Агаарын чанарын тойм мэдээг 7 хоногоор 52 удаа, сараар 12 удаа, хүйтний улирлаар 7 удаа, БОХ-1 маягтаар 1 удаа гаргаж агаар.mn, weather.gov.mn цахим хуудсанд байршуулаад байна. Агаарын чанарын 7 хоног, сар, хүйтний тойм мэдээ, мэдээллийг Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл, БОУАӨ-ийн сайд, Төрийн нарийн бичгийн дарга, мэргэжилтэн, Тагнуулын Ерөнхий газар, Эрчим хүчний сайд, Нийслэлийн Агаар орчны бохирдолтой тэмцэх газар, НЭМҮТ зэрэг байгууллагад тухай бүрд цахимаар өгч ажиллаж байна. Улаанбаатар хотын агаарын чанарын өдөр тутмын мэдээ гаргаж мэдээ, мэдээллийг түгээн ажиллаж байна.	100%
ГУРАВ. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
Стратеги төлөвлөгөөний зорилго: Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, төрийн үйлчилгээг хүртээмжтэй, ил тод хүргэх, тасралтгүй, байнгын ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн, хүний нөөцийг удирдах, хяналт, хариуцлага, урамшууллыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 13, 15, 6.5-р заалт							
4	Зорилт 4: Бүх төрлийн төлөвлөлтийг сайжруулах	Улсын төсөв	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үнэлгээ, хувь	91.0	92.0	2024 онд Ус цаг уурын албаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх салбарын сайдын тушаалын төслийг боловсруулан, 100 жилийн хүрээнд зохион байгуулагдах ажлын төлөвлөгөөг сайд, газрын даргын тушаалаар батлуулан хэрэгжүүлэх санхүүгийн болон зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаа. Нийт 400.0 гаруй сая төгрөгийн үйл ажиллагааг төлөвлөн гүйцэтгэлээ. Үүнд: - Үйл ажиллагаа бүрийн нарийвчилсан төсвийн	100%

1	2	3	4	5	6	7	8
						<p>тооцоог хийн санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр ангилан төсвийн хөрөнгөөр, хандив тусламжаар, зохион байгуулалтын хүрээнд гэсэн төрөл бүрээр тооцоо судалгааг хянан гүйцэтгэлийг ханган бүрэн санхүүжүүлэв. 100 жилийн зууны зууны манлай салбар нэгжийг шалгаруулах, тэмдэг, медаль, цүнх, баярын хурлын болон хүлээн авалтын заал,, баярын хурлын зохион байгуулалтыг хариуцан ажилласан. Ус цаг уурын алба үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан ДЦУБ, Бүсийн II-р төв, БНСУ, БНХАУ, БНТУ, ОХУ болон бусад хамтарч ажилладаг олон улсын байгууллагуудын төлөөлөлд албан бичиг, урилга явуулсан бөгөөд 100 жилийн ойн арга хэмжээнд зориулж ирүүлсэн дүрст болон үгэн мэндчилгээг орчуулж, талархлын хариу захидлуудыг бичиж илгээсэн.</p>	
4.1	<p>Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын антены цамхагийн байрны дутуу санхүүжилтийг шийдвэрлэх /2023 онд дүүсаагүй/</p>	1387.8 Улсын төсөв	Ажлын гүйцэтгэл	<p>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 01/7565 бичгийн дагуу барилга угсралтын ажлын материалын үнийн зөрүү олгох гэрээг “Чинбат” ХХК-тай шинэчлэн байгуулж материалын үнийн зөрүү 282.9 сая төгрөгийг олгож ажилласан</p>	<p>Барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэлийн материалыг бүрдүүлэн Сангийн яаманд хүргүүлж үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлүүлсэн байна</p>	<p>“Чинбат” ХХК-тай материалын үнийн зөрүү болох 1,3 тэрбум төгрөгийн ажлын тендерийг зарлах ажлыг зохион байгуулж санхүүжилтийг олгосон. Чанарын баталгааг гаргуулан авсан бөгөөд тухайн байрны зоройн давхрын ус шүүрэлтийг зогсоох, дээрийн ус зайлуулах хоолойг засварлах ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна. Мөн гүйцэтгэгчийн гэрээг барилгын хөгжлийн төв, Захиалагч, ашиглагч байгууллага хамтран дүгнэж баталгааны 168 сая төгрөгийн чөлөөлөх ажлыг хийсэн. Гүйцэтгэгчээс ашиглалтын явцад гарсан доголдол, эвдрэл гэмтэл, засварын ажлыг хийлгэсэн. “Глобал телеком” ХХК-ны материалын үнийн зөрүү 139.3 сая төгрөгийг 2025 оны хөрөнгө оруулалтын зардалд улсын төсөвт суулгахаар саналаа хүргүүлсэн.</p>	100 %

1	2	3	4	5	6	7	8
4.2	Ус цаг уур, орчны шинжилгээний төв болон өртөөний барилга барих; /2023 онд дуусаагүй/ 2024 онд шинээр төвийн 3, өртөөний 4 барилга барина	5070.4 Улсын төсөв	1. Өвөрхангай Хужирт сумын Цаг уурын өртөөний байрыг ашиглалтад оруулсан эсэх 2. Ус цаг уур, орчны шинжилгээний төв, өртөө шинээр барих байр ашиглалтад оруулсан эсэх	2023 онд Өвөрхангай Хужирт сумын Цаг уурын өртөөний байрыг 205.0 сая төгрөгийг олгож ажилласан	1. Барилгын ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтийг хангаж, хууль, журмын дагуу гүйцэтгэлийн материалыг Сангийн яаманд хүргүүлж үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлүүлнэ 2. Барилга барих тендер зарлаж, барилгын ажлыг эхлүүлсэн байна	Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор аймгийн төвийн барилга тендер зарлан гэрээ байгуулж, ажлыг эхлүүлсэн. Ажлын гүйцэтгэл Өвөрхангай, Баянхонгор аймгуудад 60-70 хувийн гүйцэтгэлтэй, Өмнөговь аймаг эхлэх шатандаа явагдаж байна. Хөвсгөл аймгийн өртөөний 3 барилга тендерт шалгарсан компанитай гэрээ байгуулан ажиллаж байна. Эдгээр ажлуудыг он дамнасан санхүүжилт хийлгэхээр төсвийн хууль батлагдсан тул ирэх жилд ашиглалтад бүрэн хүлээлгэн өгөх гэрээтэй ажиллаж байна. Өвөрхангай аймгийн Хужирт сумын Цаг уурын өртөөний байр ашиглалтад орсон.	100%
4.3	Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн тоног төхөөрөмж	105 Улсын төсөв	Тоног төхөөрөмжөөр хангагдсан эсэх		Төв аймгийн УЦУОШТ-д шаардлагатай тоног төхөөрөмж, ажлын тооцоог Сангийн яаманд илгээж, санхүүжилтийг шийдвэрлүүлнэ	Төв аймгийн УЦУОШТ-ийн захиалгаар нийлүүлэх тоног төхөөрөмжийн саналыг авч, тендерийг газраас Үнэлгээний хороо байгуулан зарлаж гүйцэтгэгчийг сонгон гэрээ байгуулан 37 нэр төрлийн нэн шаардлагатай техник хэрэгсэл, хурлын заалны иж бүрэн тоноглол, хэрэгсэл, Хөдөө аж ахуйн цаг уур, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх, байгаль цаг агаарын үзэгдэл, бодит байдлыг цаг алдалгүй буулгах орчин үеийн студийн тонго төхөөрөмжөөр бүрэн хангагдсан.	100%
4.4	Ус цаг уур, орчны шинжилгээний байгууллагуудын байр, сантехникийн их засвар хийх	2900.0 Улсын төсөв	Их засвар хийгдсэн эсэх Тоног төхөөрөмжөөр хангасан эсэх	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/174 дүгээр тушаалын дагуу 17 их засварын ажил хийгдэх 500 сая төгрөг батлагдсан.	Их засварын ажлууд хийгдэж дууссан байх, гүйцэтгэлийн баримтуудыг холбогдох журмын дагуу Сангийн яаманд хүргүүлж санхүүжилтийг бүрэн шилжүүлэх ажлыг зохион байгуулна	Салбарын сайд өөрийн багцаас цаг уур, орчны шинжилгээний салбарын 15 байгууллагын 29 их засвар, зарим дутагдаж байгаа хөрөнгө оруулалт, байгууллагын урсгал засварын ажилд 1,9 тэрбум төгрөгийг шийдвэрлэн өгсөн. Ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг төсвийн шууд захирагч, орон нутгийн Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулан, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. Энэхүү хөрөнгө оруулалтаар тус газрын хуучин байрны их засвар,	100%

1	2	3	4	5	6	7	8
				Үүнээс 16 их засвар хийгдэж, Ховд аймгийн их засварын 45.0 буцсан		сантехникийн их засвар, авто гаржийн их засварын ажлын даалгаврыг гарган Үнэлгээний хороог байгуулан ажиллаж, гүйцэтгэгчээр “БиБи Нэгүн” ХХК, “Ванчин занги” ХХК шалгаран ажлыг чанартай гүйцэтгэж дууссан.	
4.5	“Цаг уур, орчны шинжилгээний салбарын хөрөнгө оруулалт, урсгал төсвийн төсөл боловсруулах	Улсын төсөв	Хуулийн хугацаанд холбогдох журмын дагуу төсвийн болон хөрөнгө оруулалтын санал хүргүүлсэн байдал, хэрэгжилтийн хувь	МУ-ын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаарт оруулах санал, урсгал төсвийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хуулийн хугацаанд хүргүүлж батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан	МУ-ын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаарт оруулах санал, хуулийн хугацаанд хүргүүлж, батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан байна	ЦУОШГ-ын харьяа 26 байгууллагын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, хөрөнгө оруулалтын саналыг тус тус боловсруулан газрын удирдлагуудад танилцуулан холбогдох байгууллагуудад хүргүүллээ. Төсвийн төслийг нэн хэрэгцээтэй дутагдаж байгаа зардлуудыг тусган боловсрууллаа. Хөрөнгө оруулалтын төслийг барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, зураг төсөв гэсэн ангиллаар боловсруулав. 2024 оны хөрөнгө оруулалт болон урсгал төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын зохион байгуулан гүйцэтгэлийг ханган ажиллаа.	100%
4.6	Ус цаг уур, орчны шинжилгээний салбараас МУ-ын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаарт оруулах	Улсын төсөв	Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарт оруулах саналыг хуулийн хугацаанд хүргүүлсэн байдал	26 байгууллагын 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарт оруулах саналыг хуулийн хугацаанд	26 байгууллагын 2025 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарт оруулах саналыг хуулийн хугацаанд Сангийн яамд хүргүүлж, FISCAL программд шивж оруулан, нэгтгэн боловсруулсан байна	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын нэн хэрэгцээтэй дутагдаж байгаа зардлуудыг тусган боловсруулж 2025 оны төсвийн төсөл 2026-2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, хөрөнгө оруулалтын саналыг тус тус боловсруулан газрын удирдлагуудад танилцуулан Сангийн яамны FISCAL, PIMIS програмуудад тус тус оруулж холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд нь цахим болон цаасаар хүргүүлсэн.	100%

1	2	3	4	5	6	7	8
	саналаа боловсруулж, харьяалагдах дээд шатны байгууллагад хүргүүлэх, хамгаалах			Сангийн яамд хүргүүлж, FISCAL программд шивж оруулан, нэгтгэн боловсруулсан			
4.7	Салбарын болон агентлагийн санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах, батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулах, төсвийн зарцуулалтад хяналт тавих	Улсын төсөв	Салбарын болон байгууллагын батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулахад хяналт тавьсан байдал	Харьяа байгууллага болон газрын 2023 онд хүрэлцэхгүй зардлыг тооцож, хэмнэгдэж байгаа зардлын төсвөөс зохицуулалт хийх саналыг Сангийн яаманд хүргүүлэн зохицуулж ажилласан	Салбарын болон агентлагийн санхүүгийн ажиллагааг зохицуулах, батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулах, төсвийн зарцуулалтад хяналт тавина	2024 оны салбарын урсгал төсвийн санал 75.6 тэрбум төгрөгийн төсвийн санал хүргүүлсэн боловч 66.5 тэрбумаар батлагдсан, мөн 4 дүгээр сарын 1-нээс орон нутгийн нэмэгдэлтэй холбогдуулан цалин, цалингийн ашгийн татвар, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бусад бараа ажил үйлчилгээний зардлын төсөв хүрэлцэхгүйгээс шинжилгээний ажил доголдоход хүрсэн учраас Салбарын сайдад төсвийн тооцоо болон харьяа байгууллагуудаас ирүүлсэн албан тоотын хамт хүсэлт хүргүүлж сайдын багцаас 152.9 сая төгрөг, газрын даргын 2024 оны А/101, А/281 А/324 дүгээр тушаалаар 424.6 сая төгрөг, нийт 577.3 сая төгрөгийн өрийг шийдвэрлүүлж ажилласан. Төсвийн зарцуулалтад хяналт хийж, үр ашигтай зарцуулж ажиллаж байна. 2024 оны үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын жилийн төлөвлөгөө 93,239.4 мянган төгрөг, 2024 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар Цаг уурын салбарын орлогын гүйцэтгэл 716,131.8 мянган төгрөгийн орлогын гүйцэтгэлтэйгээр ажиллаж байна. Салбарын хөрөнгө оруулалт болон урсгал зардлын төсвийн хуваарийг цаг тухай бүрд саналыг тусган хяналт тавьж хэрэгжүүлэв.	100%

1	2	3	4	5	6	7	8
4.8	“Нягтлан бодох бүртгэл, аж ахуйн үйл ажиллагааны төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулахад нэгдсэн удирдлагаар хангаж	Улсын төсөв	Төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулалтад хяналт тавьсан байдал, үйл ажиллагааны хэрэгжилт	Газар болон харьяа байгууллагын 2022 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан, 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж Сангийн яамны Э-тайланд шивж, төсвийг төвлөрүүлсэн	Газар болон харьяа байгууллагын 2023 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан, 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг нэгтгэн Сангийн яамны Э-тайланд шивж, төсвийг төвлөрүүлэн БОАЖЯаманд хуулийн хугацаанд хүргүүлсэн байна	1. 2023 оны жилийн эцсийн аппаратын болон төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн бэлтгэл ажлын талаар харьяа 25-н байгууллагуудад албан тоотор заавар зөвлөмж явуулж тайланд хавсаргах иж бүрдлийг хөтөлбөр арга хэмжээ тус бүрээр нь шалгаж алдаа гаргасан байгууллагын нягтлан бодогчид зөвлөмж өгч засуулж ажилласан. 2. Шинээр томилогдсон Улаанбаатар, Сүхбаатар, Говьсүмбэр, Дархан УЦУОШТ-ийн нягтлан бодогчид мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгч ажилласан. Мөн Архангай, Булган, Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Өмнөговь, Өвөрхангай, Төв, Орхон, Завхан, Ховд, Сэлэнгэ, Хөвсгөл, аймгуудын УЦУОШТ-ийн нягтлан бодогчдод 2023 оны жилийн эцэс, 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн талаар зөвлөмж өгч нягтлан бодох бүртгэлийн бичилтийг нь шалгаж буруу бичсэн бичилтийг нь засаж тайланг зөв болгон залруулж ажилласан. 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтээр 26 байгууллага “Өөрчлөлт” дүгнэлт авч, төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт авч ажилласан.	100%
4.9	“Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах, олон нийтэд	Улсын төсөв	Мэдээ, мэдээллийг олон нийтэд тухай бүр хүргэсэн байдал, хувь	Жил, сар, тухай бүр оруулах төсөв, худалдан авах ажиллагааны мэдээлэл, төсөв, тайланг хуулийн	2024 онд байгууллагын цахим хуудас, Шилэн дансанд нийтлэх мэдээллүүдийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна	Газрын даргын баталсан хуваарийн дагуу агентлагийн 2023 оны 12 сар, IV дүгээр улирлын тайлан, 2024 оны 1-11 сар, I, II, III дугаар улирлын тайлан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тухай бүр, өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд	100%

1	2	3	4	5	6	7	8
	мэдээллийг хүргэх” Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл			хугацаанд нь байршуулсан		зарцуулсан тайлан, тухайн жилийн төсөвт өөрчлөлт орсон нэмэлт өөрчлөлт, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн хамт, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, санхүүгийн тайлангуудыг шилэн дансны тухай хуулийн хугацаанд бүрэн байршуулж ажилласан. Худалдан авалтуудын тушаал шийдвэр гэрээ болон бусад баримтуудыг сканердаж оруулж шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулж ажилласан.	
4.10	Холбогдох конвенцын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг хангаж ажиллах	Улсын төсөв	ДЦУБ-аас зохион байгуулсан олон улсын хурал, сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	58 албан хаагч	58-аас доошгүй албан хаагч	ДЦУБ-ын Ажиглалт, дэд бүтэц, мэдээллийн системийн комиссын 3 дугаар хуралд ГХЯ, БОУАӨЯ-ны хамтын ажиллагааг хангаж, хуралд газрын дарга цахимаар оролцов. Мөн 10 дугаар сарын 29-31 хүртэл ДЦУБ-аас гишүүн орны шинээр томилогдсон байнгын төлөөлөгч нарын сургалтад биеэр оролцон илтгэл тавьсан. Дэлхийн цаг уурын өдрийг тохиолдуулан зохиосон цахим хурал болон ДЦУБ Нисэхийн цаг уурын төвтэй хамтран хэрэгжүүлж буй шинэ нисэх онгоцны буудал дээр суурилуулах нөөц автомат станцын худалдан авалт ба техникийн нөхцөлийн талаарх хуралд цахимаар оролцов. ДЦУБ-ын холбогдох газруудаас ирүүлсэн нийт 67 албан бичгийг холбогдох дарга, мэргэжилтнүүдэд хүргүүлж, хариу өгч ажиллав. ДЦУБ-ын 2024 оны магистр, докторын тэтгэлэгт хөтөлбөрийн мэдээллийг орчуулж, байгууллагын цахим хуудаст тавьж, олон нийтэд хүргэв. Сургалтад албан хаагч 60 гаруй хамрагдсан байна.	100%
		Улсын төсөв	БНХАУ-ын Цаг уурын газар болон Монгол улсын ЦУОШГ хооронд	Бээжин хотод болсон хоёр талын 17 дугаар	Уулзалтын протоколд тусгагдсан 7 чиглэлийн 11 ажлын	БНХАУ-ын Цаг уурын албатай Цаг уурын шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллах хамтарсан ажлын хэсгийн 17 дугаар уулзалтын протоколын хүрээнд Урт	100%

1	2	3	4	5	6	7	8
			хамтран ажиллах хамтарсан ажлын хэсгийн 16 дугаар уулзалтын протоколын хэрэгжилт, хувь	уулзалтад оролцож, уулзалтын протокол, үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан баталгаажуулсан	хэрэгжилтийг хангаж ажилласан байна	хугацааны прогнозыг хамтран гаргах БНХАУ-ын Циндао хотод болсон “Азийн бүс нутгийн уур амьсгалын хяналт, үнэлгээ, урьдчилсан төлөв” сэдэвт 20 дугаар хуралд УЦУОСМХ-ийн урт хугацааны урьдчилсан мэдээ хариуцсан ерөнхий инженер Б.Жаргалан ЦУОШГ-ын зардлаар, эрдэм шинжилгээний ажилтан Э.Мөнхжаргал БНХАУ-ын цаг уурын албаны зардлаар тус тус оролцов. Мөн уг протоколын хүрээнд БНХАУ-ын цаг уурын албаны мэргэжилтнүүд Монгол улсад ирж ажиллах, ЦУОШГ-аас студийн 1 мэргэжилтэнг БНХАУ-д туршлага солилцохоор илгээн ажиллуулсан.	
		Улсын төсөв	Монгол улсын Цаг уур, орчны шинжилгээний газар, БНСУ-ын Цаг уурын газрын хооронд цаг уурын салбарт хамтран ажиллах 9 дүгээр уулзалтын протоколд хэрэгжилт, хувь	Улаанбаатар хотод хоёр талын 10 дугаар уулзалтыг зохион байгуулалж, уулзалтын протокол, үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан баталгаажуулсан	Уулзалтын протоколд тусгагдсан 6 чиглэлийн 7 ажлын хэрэгжилтийг хангаж ажилласан байна	Уг протоколын хүрээнд Өвөрмонголын Цаг уурын газраас 4 мэргэжилтэн Өмнөговь аймгийн Даланзадгадад радарын хяналт, шинжилгээ хийхээр ирж ажилласан. БНХАУ-ын засгийн газрын буцалтгүй тусламжаар Өмнөговь болон Говь-Алтай аймагт аэрологийн станц, ус төрөгчийн генератор суурилуулах ажлыг эхлүүлсэн. БНСУ-ын цаг уурын алба, ЦУОШГ-ын хооронд цаг уурын салбарт хамтран ажиллах асуудлаар байгуулсан 10 дугаар уулзалтын протоколын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөгжлийн албан тусламжийн ёсны хүрээнд хэрэгжүүлж буй “Цаг уурын мэдээллийн нэгдсэн систем үүсгэх, Өвөрхангай аймгийн төвд аэрологийн судалгааны станц суурилуулах” төслийн ажил хэрэгжилтийн шатандаа явж буй бөгөөд БНСУ-ын мэргэжилтнүүд энэ оны 6 дугаар сарын сүүлээр Өвөрхангай аймагт ирж ажилласан бөгөөд 12 дугаар сард ус төрөгчийн генераторыг суурилуулах, аюулгүй ажиллагааны талаар сургалтыг ороход бэлэн болоод байна. Мөн энэхүү төслийн хүрээнд ЦУОШГ-ын мэргэжилтнүүдийн 10 хүний бүрэлдэхүүнтэй	100%

1	2	3	4	5	6	7	8
						<p>баг 7 дугаар сарын 28-аас 8 дугаар сарын 03-ны өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотноо Солонгосын цаг уурын хүрээлэнгээс зохион байгуулж буй “Монгол улсад цаг уурын ажиглалтын мэдээллийн нэгдсэн систем суурилуулах нь” сэдэвт сургалтад амжилттай хамрагдан сертификат авсан.</p> <p>11 дүгээр сарын 6-8-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Тэжон хотноо БНСУ-ын Цаг уурын газраас зохион байгуулж буй “Зүүн Азийн өвлийн улирлын уур амьсгалын төлөв” сэдэвт 12 дугаар олон улсын хуралд Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн Цаг агаар, орчны тоон загварчлал, судалгааны хэлтсийн ерөнхий технологич инженер Б.Жаргалан, эрдэм шинжилгээний дэд ажилтан Э.Мөнхжаргал нар илтгэл тавьж амжилттай оролцсон.</p>	
		Улсын төсөв	Цаг уур, орчны шинжилгээний газар болон Тайландын Хааны бороо, хөдөө аж ахуйн агаарын тээврийн газар хооронд “Цаг агаарт зориудаар нөлөөлөх талаарх техникийн хамтын ажиллагааны хамтарсан хөтөлбөр”- ийн хэрэгжилт, хувь	“Монгол Улсад Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг хөгжүүлэх” төслийг боловсруулж, Тайландад суугаа МУ-ын элчин сайдаар дамжуулан Тайландын засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж байна	Тайландын "Хааны бороо" байгууллагаас 10 мэргэжилтэн ЦУОШГ-т болон Хэнтий аймагт ирж ажиллана. Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлын үр дүнг үнэлэх системийг боловсруулж, туршсан байна	2021 оны 09 дүгээр сард Тайландын Хаант улсын Хааны бороо, хөдөө аж ахуйн агаарын тээврийн газар болон ЦУОШГ-ын хооронд техникийн хамтын ажиллагааны хамтарсан хөтөлбөрийг байгуулсан бөгөөд нийтдээ 3 жилийн хугацаатай хэрэгжих, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан 2024 оны 9 дүгээр сард хугацааг дуусахад хамтран дүгнэж сунгаж ажиллахаар 2024 оны 05 дугаар сарын 16-19-ний хооронд Тайланд улсаас ирсэн 9 хүний бүрэлдэхүүнтэй мэргэжилтнүүдийг ЦУОШГ-т айлчлал хийсэн уулзалтаар тохиролцов. Хамтарсан хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх, мөн 2027 он хүртэл сунгах ажлуудыг цахимаар хийх боломжтой гэж үзсэн.2024 оны 5 сарын 16-ны өдөр ЦУОШГ дээр хамтарсан хурал хийж, холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан ба 2021-2024 оны хооронд цаг агаарт зориудаар нөлөөлөхөд шаардлагатай арга	100%

1	2	3	4	5	6	7	8
						<p>зүй, технологийн сургалтууд зохион байгуулсан талаар Тайланд Монгол улсын мэргэжилтнүүд харилцан мэдээлэл хийж, хамтын ажиллагааны хөтөлбөрийг сунгах шийдвэр гарч, ЦУОШГ-ын ахлах мэргэжилтэн Г.Амгалан, ахлах мэргэжилтэн С.Жавзмаа УЦУОСМХ-ын ЦАОТЗСХ-ийн дарга Г.Батжаргал нарыг тус хөтөлбөрийн ажлын хэсгийн багт оруулсан. Төсөл хэрэгжих хугацаанд шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, харилцан туршлага солилцож ажиллахаар болов. Мөн Өмнөговь аймгийн ЗДТГ-аас сүүлийн жилүүдэд хур тунадас бага, ган, зуд болж буйтай холбоотойгоор Тайланд улсын Хааны борооны газрын мэргэжилтнүүдтэй хамтарч ажиллах хүсэлтийн дагуу тус аймагт , Тайланд улсын болон цаг уурын газрын мэргэжилтнүүдийн баг 5 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд Өмнөговь аймагт ажиллаж, Өмнөговь аймгийн төлөөлөгч нартай хур бороо нэмэгдүүлэх технологийг нэвтрүүлэх чиглэлээр хамтарч ажиллахаар болов. Уг төслийн хүрээнд 2024-2027 оны хооронд хэрэгжих ба эхний жил суурь судалгааг хийж, дараагийн жилүүдэд технологи нэвтрүүлэх асуудлыг үр дүнд тулгуурлан тайлан, гарын авлага гаргах болно. Өмнөговь аймгийн УЦУОШТөвд ажиллахдаа цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаатай танилцаж, туршилтын пуужин харван үзүүллээ. АСЕАН цаг агаарт зориудаар нөлөөлөх төвийн байнгын нарийн бичгийн даргын үүргийг Тайландын Хаант улсын Хааны бороо, хөдөө аж ахуй, агаарын тээврийн газар гүйцэтгэдэг бөгөөд цаг агаарт зориудаар нөлөөлөх чадавхыг дээшлүүлэх, бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх</p>	

1	2	3	4	5	6	7	8
						зорилготой цаг агаарт зориудаар нөлөөлөх төвийн 2 дахь удаагийн олон улсын хуралд манай газраас холбогдох инженер амжилттай оролцон илтгэл тавьж хэлэлцүүлээ.	
		Улсын төсөв	Гадаад орнуудын цаг уурын байгууллага, цаг уурын тоног төхөөрөмж үйлдвэрлэгч компаниудтай байгуулсан гэрээний хэрэгжилт, хувь	БНХАУ, Франц, Финланд, Англи улсын eOsphere зэрэг улсын 4 компанитай борооны пуужин, радио зонд, сэлбэг хэрэгсэл худалдан авах, программ хангамжийн техник үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж, хэрэгжүүлж ажилласан	БНХАУ, Франц, Финланд, Англи улсын eOsphere зэрэг улсын 4 компанитай борооны пуужин, радио зонд, сэлбэг хэрэгсэл худалдан авах, программ хангамжийн техник үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж, хэрэгжүүлж ажилласан байна	БНХАУ-ын “Beijing Auxin Chemical Technology” компанид борооны пуужинг гаалиар нэвтрүүлээд шаардлагатай нэмэлт албан бичгүүдийг МУ-ын ГХЯ, Гаалийн ерөнхий газар, БНХАУ-д суугаа МУ-ын элчин сайдын яам, ӨМӨЗО-ны Гаалийн газруудад хүргүүлж, пуужингийн лицензийн сунгалтыг хийлгэсний дагуу 7 сарын 10-нд 1150 пуужин, 22 ширхэг пуужин хөөргөгчийн удирдлагыг боомтоор оруулахаар болов. Францын “MODEM” компанитай 1400 зонд худалдан авах гэрээ байгуулж, гэрээг орчуулан төлбөрийг шилжүүлэх, зондыг хүлээж авахад шаардлагатай материалыг бүрдүүлэв. Финландын “Vaisala Oyj” компанитай цаг уурын хэмжих хэрэгсэл худалдан авах гэрээ байгуулсан. Хэмжих хэрэгслийг хүлээн авах ажил явагдаж байна. Англи улсын eOsphere Limited компанитай программ хангамжийн техник үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж үйлчилгээний төлбөрийг шилжүүлэхэд шаардлагатай материалыг бүрдүүлэв. Түлш, мөндөр сарниулагчийг нийлүүлэх ажлын судалгааг хийж байна	90%
		Улсын төсөв	Монгол улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын (хилийн усыг ашиглах, хамгаалах тухай) хэлэлцээрийн дагуу мэдээ,	Шинжилгээний 2022 оны тайланг ОХУ-ын ажлын хэсэгт илгээж, Сэлэнгэ мөрний хил орчмын бүсээс усны	Хяналт-шинжилгээний 2023 оны үр дүнг нэгтгэн тайланг хугацаанд нь илгээж, хамтарсан судалгаа, экспедиц ажиллаж, хуралд зөвлөгөөнд оролцсон байна	2023 оны 08 дугаар сарын 21-25-ний хооронд ОХУ-ын Байгалийн нөөц, экологийн яамны харьяа Ус цаг уур, байгаль орчны хяналтын холбооны алба болон Монгол улсын талаас Сэлэнгэ аймгийн БОШЛ-ийн албан хаагчдын хамтарсан ажлын хэсэг Сэлэнгэ мөрний уснаас сорьц авч шинжилгээг хийж, шинжилгээний дүнг нэгтгэн ЦУОШГ-ын	100%

1	2	3	4	5	6	7	8
			мэдээлэл солилцсон эсэх	биологийн дээж авах хамтарсан экспедиц ажиллаж, ОХУ-д болсон Хилийн усны бага хуралд оролцсон		даргын 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн G3(16) 24 дугаартай албан бичгээр ОХУ-ын талд хүргүүлсэн. ОХУ-ын цаг уурын байгууллагатай байгуулсан 9 дүгээр уулзалтын протоколыг дүгнэх, 10 дугаар уулзалтын тов тодорхой/дайн/ шалтгааны улмаас гараагүй байгаа болно.	
5.1	Зорилт 5: Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, сургалт, сурталчилгааны хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллана	Улсын төсөв	байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах чиглэлээр хийж түгээсэн контентын тоо	6	10	Тус газрын даргын 2021оны А/240 дугаар тушаалаар Цаг уур, орчны шинжилгээний газрын төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 2022-2024 онд хэрэгжүүлэхээр батлуулсан. Уг хөтөлбөрийн хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны 3 зорилт, 16 арга хэмжээг төлөвлөж 100 хувь хэрэгжүүлж ажилласан Тайланг хавсаргав. Газрын даргын баталсан 2024 оны “Сургалтын төлөвлөгөө”-ний дагуу тус газраас харьяа байгууллагын албан хаагчдад 9 сургалт зохион байгуулсан. Мөн тус газрын албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах зорилгоор гадаадын 15 сургалтад 21 албан хаагч, дотоодын 13 сургалтад 31 албан хаагчдыг хамруулсан. Тус бүрийн дэлгэрэнгүй тайланг хавсаргав.	100%
5.2	Төрийн албаны тухай хууль тогтоомж, тогтоол шийдвэр, стандартын хэрэгжилтийг хангаж, харьяа 26 байгууллага, газрын нэгжийн	Улсын төсөв	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг тогтоол, журмын дагуу батлуулж, дүгнэсэн байх	2023 онд 26 байгууллага, 6 хэлтэс, 68 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан, хяналт, үнэлэлт өгч	2024 оны 26 байгууллага, 6 хэлтэс, 68 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан, хяналт, үнэлэлт өгнө	Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 100 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу тус газар, 6 хэлтэс, албан хаагчдын болон 26 харьяа	95%

1	2	3	4	5	6	7	8
	болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнах, урамшуулах			урамшуулал олгосон		байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулсан. Хагас жилийн тайлан хүлээн аваад хяналт шалгалт хийж дүгнэсэн одоо жилийн эцсийн тайланг хүлээн авч дүгнэх ажил явагдаж байна.	
5.3	Газар, харьяа байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган тайлагнаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх	Улсын төсөв	Шалгах төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан батлуулсан байна	2022, 2023 оны үйл ажиллагаанд санхүүгийн болон технологийн дотоод аудитыг харьяа байгууллагуудад хийсэн	2023, 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд дүгнэлт хийж, хөрөнгийн тооллого явагдсан байна.	Цаг уурын ажиглалт, хэмжлийн технологи хяналт шалгалтын хувьд: 2024 онд Булган аймгийн 6 салбар, Орхон аймгийн 1 салбар, Улаанбаатар хотын 5 салбар, Төв аймгийн 1 салбар, Хөвсгөл аймгийн 12 салбар нийт 5 аймгийн 25 салбарт ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажлын технологийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Шалгалт хийгдсэн аймаг салбар бүрээр 5 удаа дүгнэлт зөвлөмжийг аймаг тус бүрээр хүргэж, тайлагнасан. Аудитын төлөвлөгөө боловсруулж батлуулсан ба төлөвлөгөөний дагуу харьяа 5 байгууллагын /Улаанбаатар хот, Орхон, Сэлэнгэ, Булган аймгуудын УЦУОШТөвүүд, УЦУСМХүрээлэн/ 2023, 2024 оны санхүүгийн тайланд хяналт шалгалт хийхээр тусгасны дагуу дээрх 5 байгууллагад хяналт шалгалт хийж, төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн аудит хийсэн.	100%
5.4	Байгууллагын архив, бичиг баримтыг холбогдох хууль, тогтоомж, стандарт, заавар журмын дагуу эрхлэн явуулах	Улсын төсөв	Заавар, журам, стандартыг мөрдсөн байна	2022, 2023 оны жилийн тайлан гаргасан, баримт бичгийг хууль, журмын дагуу эмх цэгцтэй хадгалж ажилласан	2023 оны болон 2024 жилийн тайлан гарсан байна. Баримт бичгийг хууль, журмын дагуу эмх цэгцтэй хадгалж ажилласан байна	Газрын даргын А тушаал-3 хн, Б тушаал -1 хн нийт 1000ш цаасан суурьтай баримтыг цахимжуулж 331.6 MB хэмжээтэй File-ийг байгууллагын архивын эрэл хайлтын ORDERS программд байршуулж 33 албан хаагчдад 124 баримтаар үйлчилсэн. Баримтын данс бүртгэлд 29250 ш цаасан баримтыг стандартын дагуу үдэж, хавтаслан Байнга хадгалах хадгаламжид 42 хн, түр хадгалах 69 хн, 70 жил хадгалах	100%

1	2	3	4	5	6	7	8
						6 хн буюу нийт 117 хадгаламжийн нэгжийг байгууллагын архивт хүлээлгэн өгч баяжилт хийсэн. Нийт 148 албан хаагчдад 591 баримтаар баримтын бүртгэл үйлдэж үйлчилсэн. Архивын баримтын хадгалалт хамгаалалтын ажлыг зааврын дагуу мэргэжлийн түвшинд хийж архивын баримтын өрөөний ариутгалыг нийт 2 удаа, цэвэрлэгээг нийт 52 удаа, их цэвэрлэгээг нийт 4 удаа. эрүүл ахуйн нөхцөл, гэрэл, дулаан, чийгийг нийт 57 удаа хэмжиж, стандартад нийцүүлэн ариутгал, цэвэрлэгээ хийсэн.	
5.5	Ус, цаг уурын байгууллагын 100 жилийн ойн арга хэмжээ зохион байгуулах	Улсын төсөв	Ойн арга хэмжээг зохион байгуулсан эсэх	0	100	2024 онд Ус цаг уурын албаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх салбарын сайдын тушаалын төслийг боловсруулан, 100 жилийн хүрээнд зохион байгуулагдах ажлын төлөвлөгөөг сайд, газрын даргын тушаалаар батлуулан хэрэгжүүлэх санхүүгийн болон зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаа. Нийт 400.0 гаруй сая төгрөгийн үйл ажиллагааг төлөвлөн гүйцэтгэлээ. Үүнд: - Үйл ажиллагаа бүрийн нарийвчилсан төсвийн тооцоог хийн санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр ангилан төсвийн хөрөнгөөр, хандив тусламжаар, зохион байгуулалтын хүрээнд гэсэн төрөл бүрээр тооцоо судалгааг хянан гүйцэтгэлийг ханган бүрэн санхүүжүүлэв. 100 жилийн зууны зууны манлай салбар нэгжийг шалгаруулах, тэмдэг, медаль, цүнх, баярын хурлын болон хүлээн авалтын заал баярын хурлын зохион байгуулалтыг хариуцан ажилласан. Ус цаг уурын алба үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан ДЦУБ, Бүсийн II-р төв, БНСУ, БНХАУ, БНТУ, ОХУ болон бусад хамтарч ажилладаг олон улсын байгууллагуудын төлөөлөлд албан бичиг, урилга явуулсан	100%

1	2	3	4	5	6	7	8
						бөгөөд 100 жилийн ойн арга хэмжээнд зориулж ирүүлсэн дүрст болон үгэн мэндчилгээг орчуулж, талархлын хариу захидлуудыг бичиж илгээсэн.	
ДӨРӨВ. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт							
6.1	Зорилт 6: Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн урьдчилсан мэдээний хүртээмжийн нарийвчилсан судалгаа хийх	Улсын төсөв	Судалгааны үр дүнгээр тайлан гаргах	0	Асуулга боловсруулсан байх, асуулга явуулсан байх дүгнэлт, үр дүнг гаргасан байх	Судалгааг хийх ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг судалгааг асуулга, мэдээлэл цуглуулах гэсэн 2 хэлбэрээр хийж байна. асуулгыг google form ашиглан боловсруулж түгээсэн. Одоогоор 5700 хүн хариулсан байна. Асуулгыг аль болох малчид, тариаланчдаас авч байна. Судалгааны үр дүнг 2025/01/15-нд гаргаж, даргын зөвлөлд танилцуулахаар ажиллах байна.	90%
6.2	Ус, цаг уур, орчны өртөө, харуулын мета өгөгдлийн сан байгуулах	Улсын төсөв	Ажлын явц, гүйцэтгэл, хувь	0	Нэгдсэн арга зүйг гаргаж, 50 хувийг санд оруулсан байна	<p>Мета өгөгдлийн сан байгуулах тандан судалгааны хүрээнд ДЦУБ болон бусад байгууллагын /статистикийн газар, онцгой байдал/ мэдээллийн сангийн бүтэц, байгууллагыг судаллаа. ДЦУБ-ын OSCAR/Surface платформ, стандарт/ WMO-No.1192/-ыг орчуулж эхэлсэн. ДЦУБ-ын https://oscar.wmo.int/surface/#/ Платформоос Суурь түвшний жагсаалт гаргасан. Жагсаалтад багтах мэдээллийг өртөө, харуулаар оруулах боломжтой</p> <p>Байгууллагын болон архив мэдээллийн сангийн сайтад өртөө, харуулын мета өгөгдлийг оруулах талаар цахим сүлжээ хариуцсан инженер, АМХ-ийн дарга нартай санал солилцож ирэх жилийн ажлын төлөвлөгөөнд тусгахаар болов.</p>	50%
6.3	Уур амьсгалын өөрчлөлтийн Монгол орны экосистемд үзүүлэх		Индексүүдийн тоо	80 өртөөний 1961-2022 оны мэдээгээр уур амьсгалын 80 экстремал	80 өртөөний 2023 оны мэдээгээр цувааг уртасгаж, уур амьсгалын 80 орчим экстремал индексийг	80 өртөөний 1961-2022 оны экстремаль индекс тооцоолдог хоногийн цувааг 2023 оноор уртасгаж уур амьсгалын 80 гаруй индексийг тооцоолж, түүнээс монгол орны нийгэм эдийн засагт хамгийн их нөлөө	100%

1	2	3	4	5	6	7	8
	нөлөөллийн үнэлгээг нарийвчлан хийх	Улсын төсөв		индексийг тооцоолсон	тооцоолж, үр дүнг цахим сайтад байрлуулна	үзүүл буй 11 экстремаль индексийн үр дүнг цахим сайтад байршуулсан.	
6.4	Монгол орны уур амьсгалын өнгөрсөн болон өнөө үеийн өөрчлөлтийг 10 жилийн интервалтайгаар тооцоолж, үнэлэх	Улсын төсөв	Цувааны урт, орон зайн нарийвчлал	1991-2020 оны жилийн дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны өөрчлөлтийг орон зайн $0.0625^{\circ}\times 0.0625^{\circ}$ нарийвчлалтайгаар тооцоолсон	Агаарын температур, тунадасны 1941-2020 оны мэдээг цаг хугацааны 1 сарын, орон зайн $0.0625^{\circ}\times 0.0625^{\circ}$ нарийвчлалтай тооцоолж, Монгол орны уур амьсгалын өнгөрсөн болон өнөө үеийн өөрчлөлтийг 10 жилийн интервалтай тооцоолсон байна	1961-2022 оны 1-12 дугаар сар хүртэлх агаарын температурын 119 станц (өндөр уулын 3 станц), нийлбэр хур тунадасны 116 станцын нэгэн төрлийн цувааны тоон мэдээ бүрдүүлж, уг мэдээг ашиглан ОЖД нормыг 10 жилийн интервалтайгаар буюу 1961-1990 он, 1971-2000 он, 1981-2010 он, 1991-2020 оноор гаргаж, статистик загварын анхны нөхцөл болгон цаг хугацааны 1-р сарын, орон зайн $0.0125^{\circ}\times 0.0125^{\circ}$ -аар буулгалт хийсэн.	100%
6.5	Усны урсгалын хурд хэмжих 50ш хэмжих хэрэгслийг шалгах	Улсын төсөв	Хэмжлийн нэгдмэл байдал хангагдсан эсэх	Хэмнэлтийн тухай хуулиар ус, цаг уур, орчны шинжилгээний салбарын төсөв танагдаж, усны урсгалын хурд хэмжих багажийн шалган тохируулах ажлын санхүүжилт шийдвэрлэгдээгүй	50-аас доошгүй вертушкийг засаж, шалган баталгаажуулсан байна	Цаг уур, орчны шинжилгээний салбарын багаж, тоног төхөөрөмжийн хэмжлийн нэгдмэл байдлыг хангах арга хэмжээний хүрээнд 15 175 000 (арван таван сая нэг зуун далан таван мянга) төгрөгийн үнэ бүхий 96 ширхэг подшипник, 48 ширхэг контакттай араа, 30 ширхэг гуулин муфьт, 5 ширхэг гол, 250 ширхэг мөнгөн контакт, 3 ширхэг их бие, 2 ширхэг сэнсийг тус тус худалдан авч, аймаг нийслэлийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүдийн захиалгын дагуу усны урсгалын хурд хэмжих 50 ширхэг вертушкийг татан авч, засвар үйлчилгээ хийж, хэмжлийн хүснэгт гарган, усны урсгалын хурд хэмжих, судалгааны ажилд бэлдэж хүргүүлсэн.	100%
6.6	Ус, цаг агаарын урьдчилан сэргийлэх дунд, урт хугацааны		Супер компьютер худалдан авах, суурилуулах ажлын явц	Супер компьютерын системийг агааржуулагч,	Худалдан авалт хийгдэж, тоон загваруудыг суулгаж,	Шинэ суперкомпьютерын худалдан авах ажиллагаанд шаардлагатай мэдээ мэдээлэл гаргаж өгөх, уулзалт ярилцлагад оролцож байна. Суперкомпьютерын	50%

1	2	3	4	5	6	7	8
	мэдээ боловсруулах супер компьютерыг шинэчлэх	Гадаад зээл тусламж		тог баригчийн хамт иж бүрэн суурилуулж, сургалт хийсэн	туршилт хийсэн байна	худалдан авалтын үйл ажиллагаа гадны зөвлөх компани шалгаруулж, тендер зарлан материал хүлээн авах шатандаа явж байна.	
6.7	ДЦУБ-гаас Цаг уурын ажиглалтын мэдээлэл солилцооны WIS2.0 системийг нэвтрүүлэх	Улсын төсөв	Ажлын явц	Техникийн нөхцөлийн судалгаа хийгдэж, сургалтад хамрагдсан	Шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг худалдан авч, суурилуулсан байна	1.СМА болон NAMEM (JWG-17) хоорондын хоёр талын хэлэлцээрийн дагуу бид WIS2.0-ийг хэрэгжүүлэх болон бусад холбогдох асуудлаар хамтын ажиллагаа явуулж байна. 2025 онд WIS2.0 руу шилжихээр төлөвлөж байгаа бөгөөд СМА -тэй техник технологийн талаар онлайн уулзалтыг 2024 оны 11 дүгээр сарын 8-нд зохион байгуулж, WIS2.0-ийг хэрэгжүүлэх талаар туршлага судлав. 2.JMA WIS портал сайтыг (Интернэт GTS холболтыг оруулаад) 2025 оны 3-р сард шинэ сайтаар бүрэн солих тул 2024 оны 11 дүгээр сард холбогдож, туршилтын хуваарь болон төлөвлөгөө гаргах түвшинд ажиллаж байна 2024 оны 12 дугаар сард MSS болон JMA шинэ системийн хооронд холболтын тест хийх төлөвлөгөөтэй ажиллаж байна.	100%
6.8	Мэдээлэл солилцоо, дамжуулалтын чанарыг сайжруулах, дотоод сүлжээний тоног төхөөрөмжийг шинэчлэх	Улсын төсөв	Шинэчлэлтийн явц	Цаг уурын нэгдсэн сүлжээний DMZ сүлжээний свитчийг шинэчилж, дотоод сүлжээний хурд нэмэгдүүлж, гадаад IP хаягтай серверүүдийг	Цаг уурын нэгдсэн сүлжээний цөм роутерыг шинэчлэх, сүлжээний бүтцийг сайжруулах, шаардагдах тоног төхөөрөмжийг захиалсан байна	Цаг уурын нэгдсэн сүлжээний цөм роутерыг захиалан авч, сүлжээний тохиргоо хийгдэж байна.	95%

1	2	3	4	5	6	7	8
				нэмж холбож ажилласан			
6.9	Төрийн архивын баримтын бүрдүүлэлт хийх, цахим баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах	Улсын төсөв	1.Бүрдүүлэлтийн төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Төрөлжсөн архив, мэдээллийн нэгдсэн санд хөмрөг үүсгэгчээс жил бүр ажиглалт, хэмжилтийн мэдээний бүрдүүлэлт хийх хуваарийг батлуулан салбарын хэмжээнд мөрдүүлэн ажиллаж байна. Хөмрөг үүсгэгч 22 байгууллага цахимжуулах ажиллаа бүрэн хийсэн байна.	100%
			2. Цаасан баримтыг цахимжуулсан хувь	21	45	Хөмрөг үүсгэгч 22 аймгийн 2016-2020 оны өөрөө бичигчийн лент /термограф, гигрограф, барограф/-ийн 608,362 файл, 3,661 фолдер материал цахимжуулан авч, Аймаг, нийслэлийн дэд сангаас татаж ирүүлсэн цахимжуулсан мэдээний нөөц хувийг баримтын нэр төрөл, салбар он, сараар болгож ангилан цэгцлэх ажил хийгдэж байна. Хөмрөг үүсгэгч байгууллагууд 2024 онд 419 хадгаламжийн нэгж баримтыг цахимжуулсан. Архив мэдээллийн сангийн цахим сан буюу WAMS системд 7н аймгийн өөрөө бичигчийн лентийг нийт 111,183 зураг буюу 15167 файл оруулан ажиллаж бна. Нийт цахимжуулсан баримт нийт хадгаламжийн нэгжийн 45%-д хүрсэн.	100%
6.10	Тоон мэдээ /файл/-ний санд бүрдүүлэлт хийх, уур амьсгалын горимын мэдээллийн сан шинээр үүсгэх	Улсын төсөв	1.Цаг хугацаандаа хийгдсэн бүрдүүлэлтийн хувь	100	100	"Ус цаг уур, орчны мэдээллийн баримтын архив, мэдээллийн сангийн үйл ажиллагааны журам, жагсаалт, загвар батлах тухай" Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/173 тоот тушаалын Тав дугаар бүлгийн 5.8 заалтын дагуу тоон мэдээний санд баяжилт хийв.	99.9%

1	2	3	4	5	6	7	8
			2. Уур амьсгалын горимын шалгагдаж баталгаажсан мэдээлэл /ISX, TAB, RES/-ээр мэдээллийн сангуудад баяжилт хийсэн хувь	100	100	Уур амьсгалын горимын мэдээллийн сангийн 11340 ширхэг ISX, RES, TAB мэдээг файлаар хүлээж авсан. 36 харуулын мэдээ тасарсан. MsSQL, Cliware-ын санд 402112 мөн 8 хугацааны мэдээ, 50264 мөн хоногийн мэдээ, 4188 мөр сарын мэдээг нэмж баяжилт хийв. Цахим мэдээний үйлчилгээний вебийн санд 41907 мөр хоногийн мэдээ нэмсэн. Системүүдийн программын суулгац, мэдээллийн сан, файлуудыг нөөц хувь үүсгэн архивт хүлээлгэж өгсөн. Үүнд: MsSQL сангийн нөөц хувь 112гб, cliware мэдээллийн сан 1.6гб, виртуаль машины хуулбар 215гб, цахим мэдээний үйлчилгээний сан 372 мб, ISX-TAB-RES файл 305мб хэмжээтэй нөөц үүсгэсэн.	99.7%
			3. Цахим баримтын веб систем шинээр үүсгэх, WAMS-шинэчлэх	WAMS систем гэмтсэн	Шинэчлэн ажлуулсан байна	Төрийн худалдан авах ажиллагааны дагуу тендер шалгаруулалт явагдаж “Бек-Импекс” ХХК шалгарч 2024 оны 07 дугаар сарын 01-ээс 09 дугаар сарын 01-ны хооронд хугацаанд хийж гүйцэтгэж, 2024 оны 10 дугаар сарын 14-ны өдөр төв, орон нутгийн УЦУОШТ-ийн мэдээллийн сангийн дэд зохицуулагч нарын онлайн сургалтыг зохион байгуулж тус системийг улсын сүлжээнд нэвтрүүлэв. WAMS системийн шинэ нэвтрэх линк http://192.168.100.142:2030/ бөгөөд зөвхөн дотоод хэрэглээнд ашиглах нөхцөлтэй. Аймаг бүрд УЦУОШТ-д болон УЦУОСМХ-ийн холбогдох хэлтэст хэрэглэгчийн эрх нээж өгч хэвийн ажиллагаанд оруулсан. Системд 3.6 сая орчим 4.8тб хэмжээтэй цахим баримтыг оруулаад байна.	100%

1	2	3	4	5	6	7	8
			4.Төрөлжсөн сангийн мэдээний нөхөн бүрдүүлэлт хийх	100	100	Автомат станцын 140519 файл, 15.6G /154 станцын мэдээ/, аэрологийн 4379 файл, 0.0249G, гадаргын усны чанарын 3 файл, 0.000436G, УБ хотын агаарын чанарын 6 файл, 0.00946G, орон нутгийн агаарын чанарын 4 файл, 0.00386G, нарны цацрагийн 123 файл, 0.00058G, шороон шуурганы 1584 файл, 0.0788G, орчны цацраг идэвхжилийн түвшний 3 файл, 0.000132G, хөрсний бохирдлын мэдээ 2 файл, 0.000112G, Хөдөө аж ахуйн цаг уурын 24 файл, 0.0792G хүлээн авч нөхөн бүрдүүлэлт хийв.	100%
6.11	Цаг уурын суурин радарын мэдээллийг нэгтгэн боловсруулж харуулах мэдээллийн систем байгуулах	Улсын төсөв 40 сая	Мэдээллийн системийг үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн байх, хувь	0	100	Цаг уурын суурин радарын мэдээллийг нэгтгэн боловсруулж харуулах мэдээллийн систем шинээр бий болгох гүйцэтгэгчийг шалгаруулах тендерт Трипле девелопер зон ХХК шалгарч, 06 дугаар сарын 10-ны дотор хүлээлгэн өгөхөөр, гэрээ байгуулсан. Гэрээний дагуу программ хангамжийг хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.	100%
6.12	“WAFS-ийн кодын тайлал хийх, ОУИНБ-ийн стандарт, шаардлагыг хангах дээд агаарын зайн цаг агаарын аюултай үзэгдлийн зураглал хийх” программ хангамж боловсруулах	Улсын төсөв 40 сая	Программ хангамжийг үйл ажиллагаандаа бүрэн ашигласан байх, хувь	0	100	“WAFS-ийн кодын тайлал хийх, ОУИНБ-ын стандарт, шаардлагыг хангах дээд агаарын зайн цаг агаарын аюултай үзэгдлийн зураглал хийх” программ хангамж захиалгаар хийлгүүлэхээр ЦУОШГ-ын 2024 оны худалдан авах ажиллагааны зардалд тусгуулахаар саналаа хүргүүлж шийдвэрлүүлсэн. 9 сарын 2-нд Нислэгийн цаг уурын төвийн захиалгаар “Проактив Финсервис” компанийн боловсруулсан программ хангамжийг батлагдсан техникийн тодорхойлолтын дагуу шалгаж, хүлээн авч, акт үйлдсэн.2024 оны 10 сарын 04-ний өдрөөс эхлэн Нислэгийн цаг уурын төвийн мэдээлэл дамжуулах систем (MDS)-ийн Зураг мэдээлэл цэсний WIND TEMP-WAFS гэсэн цонхонд НЦУТ-д	100%

1	2	3	4	5	6	7	8
						боловсруулагдсан Дээд агаарын зайн цаг агаарын Онцгой үзэгдлийн зургуудыг шинээр оруулсан. Энэхүү онцгой үзэгдлийн зургийг нислэгийн үйлчилгээнд албан ёсоор бүрэн ашиглаж эхэлсэн./100%/	
6.13	Гар утасны апплекишн шинэчлэх	Улсын төсөв 20 сая	Гар утасны апплекишнийг бүрэн ажиллагаанд оруулсан байх, хувь	70	100	Одоо байгаа апп-д шинэчлэлт хийхэд боломжгүй шинээр хийх шаардлагатай гэсэн зөвлөмжийг хийсэн компаниас өгсөн тул ирэх жил гар утасны апплекишнийг шинээр хийлгэх ажлын төсвийг нэмэгдүүлж худалдан авалт хийхээр төлөвлөж байна.	0%
6.14	Байгаль орчны мэдээллийн санг өргөжүүлэх, баяжуулах	Улсын төсөв	Хөгжүүлэлт, баяжуулалт хийсэн мэдээллийн сангийн тоо	Хөгжүүлэлт-6	Хөгжүүлэлт – 8	Байгаль орчны 23 суурь мэдээллийн сан дахь 54 дэд сангийн хэвийн, шуурхай ажиллагааг ханган ажилласан. - 9 мэдээллийн санд программын хөгжүүлэлт, шинэчлэлт хийсэн. - 20 мэдээллийн санг мэдээллээр баяжуулж мэдээг хянаж баталгаажуулсан.	95%
				Баяжуулалт-25	Баяжуулалт – 25		
6.15	Ган, зудын эрсдэлийн үнэлгээний орон зайн нарийвчлалыг сайжруулах	Улсын төсөв	Хиймэл дагуулын мэдээлэл ашиглаж орчны төлөв байдлын тандан судалгаа хийсэн бүтээгдэхүүн, зураг, мэдээний тоо	Ургамалжилтын индексийн 360 зураг мэдээ	Ургамалжилтын индексийн 360 зураг мэдээ	Ургамалжилтын индексийн 360 зураг мэдээ Ургамалжилтын индексийн 360 зураг мэдээ MODIS хиймэл дагуулын 2024 оны 1 сарын 1-нээс 4 сарын 20 хүртэлх мэдээг боловсруулж Монгол орны нийт нутаг болон аймгуудын нутгаар цасан бүрхүүлийн 9 болон 198 ш зураглал, NDWI, VCI, VHI индексүүдийг ашиглан 250 метрийн нарийвчлалтай Гангийн 3 ш зураглал боловсруулан Ган, зудын эрсдэлийн үнэлгээнд ашиглав.	100%
6.16	Нагивацын хураамжийн орлогоос тодорхой хувиар санхүүжүүлэх боломжийн талаар судлан, санал		Ажлын хэсэг байгуулж, санал шийдвэр боловсруулсан эсэх	0	Нагивацын хураамжийн орлогоос тодорхой хувиар санхүүжсэн байх	ИНЕГ-ын даргын 2024 оны А/36 дугаар тушаалаар томилогдсон Агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлогын бүрдэл, орлогын тодорхой хувийг дэд бүтэц, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтад зарцуулах боломжийг судалж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн эхний хурал 2 сарын 23-нд ИНЕГ-ын хурлын зааланд хуралдсан. 5 сарын 13-нд Иргэний нисэхийн байгууллагуудад	50%

1	2	3	4	5	6	7	8
	шийдвэрийн төсөл боловсруулах	Улсын төсөв				үйлчлэх мэдээний нэр төрөл, үйлчилгээний жишиг үнийн жагсаалтыг боловсруулж, батлуулах, агаарын навигацийн орлогоос нислэгийн цаг уурын үйл ажиллагаанд ашиглах эрх зүйн орчныг судалж, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж танилцуулах “Ажлын хэсэг”-ийн 2 дугаар хуралд цахимаар оролцож төлөвлөгөөг хэлэлцэн баталсан. Төлөвлөгөөний дагуу “Нислэгийн цаг уурын үйлчилгээний төрлийг тогтоож, төлбөрийн хувь хэмжээг тооцох” талаар материал бэлтгэсэн.	
6.17	Албан хаагчдын ажлын тусгай хэрэгцээний хувцас хэрэгсэл авах	Улсын төсөв	Ажлын хувцсаар хангагдсан албан хаагчдын тоо	250	280	Ус судлалын 154 харуулд шаардлагатай ажлын хувцас болох Усны гутал/комбинзон/ 160 ширхэгийг худалдан авахаар 11 дүгээр сарын 21-нд тендер зарласан бөгөөд 5 компаний тендер ирүүлсэн. Үнэлгээний ажил хийгдэж байна..	100%
Дундаж үнэлгээ							94.05%

Товчилсон үгийн жагсаалт:	БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
	БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
	ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар
	ДЦУБ	Дэлхийн цаг уурын байгууллага
	УСУАҮХ	Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтэс
	АМСХ	Архив, мэдээллийн сангийн хэлтэс
	ОШХ	Орчны шинжилгээний хэлтэс
	УМХ	Урьдчилан мэдээлэх хэлтэс
	ЗАХ	Захиргаа, аудитын хэлтэс
	УЦУОСМХ	Ус цаг, уур орчны судалгаа мэдээллийн хүрээлэн
	НЦУТ	Нислэгийн цаг уурын төв
	БОХЗТЛ	Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори
	УЦУОШТ	Ус цаг уур орчны шинжилгээний төв

Төлөвлөгөөг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД

/С.ОДОНТУЯА/

2024 оны дугаар сарын-ны өдөр

Төлөвлөгөө тайлагнасан:

Төсвийн төвлөрүүлэн захирагч

ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



/Л.ОЮУНЖАРГАЛ/

2024 оны ¹² дугаар сарын ⁰¹ -ны өдөр